



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

Г “Монгол тэрбумтан” хоршооны хадгаламж, Ү
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол тэрбумтан” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг “Монгол тэрбумтан” хоршоо/Г.Хосбаяр/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар/Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН